

[Type text]

Төсөл

**“Талын гал” ХК-ийн 2017 оны үйл ажиллагаанд
Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлт,
ТУЗ-ийн ажлын тайлан**

Нөхөд өө !

Тайлант 2017 онд “Талын гал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хувьцааны саналын эрх бүхий 3 гишүүн, хувьцаагүй 6 гишүүн, нийт 9 гишүүнтэй ажилласан болно.

2017 онд хувь нийлүүлэгчдийн хурлаас уурхайн хэвийн жигд ажиллагааг хангаж, эдийн засгийн хэвийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хангаж биелүүлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл байдлыг дээшлүүлэх энэ ажилд тавих хяналтыг өндөржүүлэх, сахилга хариуцлагыг бүх шатанд бэхжүүлэх, осол аварьгүй ажиллах санхүү төлбөрийн чадварыг сайжруулах замаар өр авлагыг барагдуулж өндөр бүтээлтэй ажиллах зорилтыг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын өмнө дэвшүүлсэн юм.

2017 онд Төлөөлөн Удирдах Зөвлөл 4 удаа хуралдаж, 10 гаруй асуудал хэлэлцэж 12 тогтоол, 4 тэмдэглэл шийдвэр гаргаж биелэлтийг зохион байгуулж ажиллаа.

Нөхөд өө!

2017 онд бид найдвартай харилцагч, хэрэглэгчдийг өөртөө татаж, ажлын бүтээмжийг дээшлүүлэн, 226,0 мянган м3 хөрс хуулж, 90 мянган тонн нүүрс нээж, үүнээс 60,0 мянган тн нүүрс олборлож борлуулахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 242,0 мянган м3 хөрс хуулж, 95,0 мянган тн нүүрс нээж, 52449,1 тн нүүрс борлуулж, 35,0 мянган тн нүүрсний шилжих нөөцтэй ажиллаа.

[Type text]

“Талынгал” ХК нь 2017 онд нийт 1091,0 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 143,2 сая төгрөгийн ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгө болон зээлийн эх үүсвэрээс хөрөнгө оруулан, нүүрс бутлан ангилах технологийн дамжлагыг шинээр бий болгож, гол хэрэглэгч “Дөрвөлж” ХХК-ийг сайн чанарын нүүрсээр хангаж ажиллалаа.

2017 онд “Талын гал” ХК-ийн хэмжээнд хийж

гүйцэтгэсэн томоохон ажлууд

2017 онд компанийн хэмжээнд удирдлагын чадамжийг дээшлүүлэх, боловсон хүчний нөөцийг бий болгох, бичиг баримтын бүрдэлт, хууль хэрэгжилтийг сайжруулах нийт ажилтан албан хаагчдыг ХХАА-ны чиглэлээр сургалтанд хамруулах, компанийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг шинэ түвшинд гаргах чиглэлд онцгой анхаарч ажиллаа.

Мөн түүнчлэн ажилчдыг ая тохитой ажиллах нөхцөлөөр хангах, уурхайн тосгоны тохижилт, ажлын байрны чанар шаардлагыг хангах талаар нэлээд ажлыг хийж гүйцэтгэлээ.

Уулын ажлын хүрээнд Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм, холбогдох журам дүрмийг чандлан сахиж мэргэжлийн инженер техникийн ажилтан, ажилчдыг зохион байгуулалтанд оруулж батлагдсан уулын ажлын төлөвлөгөөний дагуу шинжлэх ухаанд тулгуурласан, инженерийн шийдлээр хөрс хуулалтын болон ашиглалтын үйл ажиллагааг явууллаа.

Дээр дурьдагдсан ажлуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн, хийгдэж байгаа ажлуудыг чиглэл чиглэлээр нь тайлагнавал:

1. Компанийн удирдлагын бүрэлдэхүүний чадамжийг дээшлүүлэх чиглэлээр.

- Ерөнхий инженер
- Эдийн засагч
- ХХАА-ны асуудал хариуцсан ажилтан

[Type text]

- Дотоод хяналтын ажилтан гэсэн нэр бүхий ажлын байрнууд дээр мэргэжлийн боловсон хүчнийг авч ажлуулж, тэдгээр албан тушаалтнуудын ажил үүргийн хуваарийг гарган батлаж, хийж гүйцэтгэх ажлын урт болон богино хугацааны төлөвлөгөө гаргуулж ажилласнаар тодорхой хэмжээний ахилт дэвшилт гарах нөхцөл бүрдэж байна.

Үүнд: Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага дээр байх ёстой бичиг баримтын бүрдэлтийг хангаж ажилласнаар 2017 онд хийгдсэн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын төлөвлөгөөт шалгалтанд өнгөрсөн оны буюу 2016 оны шалгалтаар илэрч байсан зөрчил дутагдлын тоо буурч үйл ажиллагаанд эерэг дүн гарч байна.

Компанийн хэмжээнд бичиг баримтын бүрдэл, албан хэрэг хөтлөлт сайжирч нийт ажилтан албан хаагчдын хурлаар нээлттэй ил тод хэлэлцүүлж тэдний санаа бодлыг тусгасан Дотоод журмыг шинэчлэн батлаж, Хөдөлмөрийн гэрээ, Эд хөрөнгийн хариуцлагын гэрээг ажилтан тус бүр дээр байгуулан хувийн хэрэг хөтлөн ажиллаж байна.

Албан хэрэг хөтлөлтийг холбогдох журам стандартын дагуу явуулах, албан хэрэг хөтлөлтийн соёлыг сайжруулах талаар санаачлагатай ажиллаж байна.

ХХАА-ны чиглэлээр дотоод боломж нөхцөлдөө тулгуурлан шаталсан сургалтуудыг нийт ажилтан албан хаагчдын дунд зохион байгуулж, өдөр, сар, улирлын аюулгүй ажиллагааны зааварчилгаануудыг өгч хэвшүүлэх, компанийн хэмжээгээр аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээнүүдийг байршуулж ажиллаа. Энэ ажлын хүрээнд аймгийн МХГ-ын байцаагч нартай хамтран сургалт зохион байгуулсан. Хэдийгээр энэ чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж байгаа боловч төгс хэмжээнд хүрч чадаагүй байгаа нь тодорхой цаг хугацаа хөрөнгө мөнгө шаардсан ажил болох нь харагдаж байгаа бөгөөд цаашид өшөө илүү ихийг хийх шаардлага компанийн удирдлагад тулгарч байна.

Дотоод хяналтын чиглэлээр орон тооны ажилтан ажлуулсанаар компанийн хэмжээнд МХГ-ын гаргасан хяналтын хуудсаар үйл ажиллагаандаа хяналт тавьж

[Type text]

гарч болзошгүй эрсдлийг урьдчилан харах түүнээс урьдчилан сэргийлэх, аливаа зөрчил дутагдлыг газар авуулалгүй таслан зогсоох боломж нөхцөл харагдаж байна.

2. Ая тохитой, аюулгүй ажлын байраар хангах, тосгоны тохижилтын чиглэлээр.

Техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зориулалтын талбайд ая тохитой засвар үйлчилгээг улирал харгалзахгүй хийх боломжийг хангах үүднээс 18x36 харьцаатай 650м² авто гражийг ашиглалтанд оруулсан бөгөөд одоогийн байдлаар дотор өнгөлгөөний шавардлага, шал цутгалт, гадна талбай тохижилтын ажил дутуу байна. /2018 оны 2-3 дугаар улиралд дутуу ажлыг хийж дуусгахаар төлөвлөж байгаа/

Аймгийн "Байгалийн засал" ОНӨҮ-ийн газраар уурхайн тосгон дээр гүн худгийн өрөм өрөмдүүлж ашиглалтанд оруулсанаар уурхайн технологийн зориулалтаар ашиглах бүрэн боломжтой болж үйл ажиллагааны зардлыг хэмнэх мөн түүнчлэн уурхайн контор, автограж цаашлаад ажилчдын орон сууцыг төвлөрсөн халаалттай болгох нийтийн халуун устай болох зэрэг хэтийн төлөвлөлтүүдэд ашиглах зорилготой.

Өөрсдийн дотоод санхүүгийн нөөц бололцоонд тулгуурлан ажилчдын амрах байр зориулалтаар 2 өрөө, гадна дотны зочид ирсэн тохиолдолд байрлуулах зориулалтаар буудлын 1 өрөө, халуун ус, хувцас солих зориулалтаар 1 өрөө, ажилчид амьдрах зориулалтаар 4 айлын 2 орон сууцыг засаж тохижуулаад байна.

Мөн нийт 542 м урттай 30 000 м² талбай бүхий аж ахуйн зориулалттай хашааг өөрийн ажилчдаар блок цохиулан барьж дуусгасанаар ажлын байрны эмх цэгц, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа сайжирсан ба аливаа гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх бүрэн боломжтой болж байна.

3. Үйл ажиллагааны цар хүрээ, маркетинг борлуулалтын чиглэлээр

[Type text]

2017 оны 9 дүгээр сард БНХАУ-аас 200тн/цаг хүчин чадалтай зөөврийн нүүрс бутлуурыг импортоор оруулж ирж ашиглалтанд оруулж өрсөлдөгч компаниудаас давуу байдал үүсгэснээр аймгийн ЗДТГазар, Дөрвөлж ОНӨҮГазартай хамтарсан 3 талт “Нүүрс худалдах, худалдан авах” гэрээг 3 жилийн хугацаатай байгуулсанаар борлуулалт тогтворжиж, компанийн хувьд үйл ажиллагаа хэвийн явуулах боломж нөхцөл үүссэн.

Сүхбаатар аймгийн нийт 13 сумаас 11 нь сумын төсөвт болон, ОНӨҮ-уудтай гэрээ байгуулж шаардлагатай нүүрсийг нийлүүлж ажиллаж байна.

Сүхбаатар сумын ЗДТГазартай хамтран ажиллах гэрээ байгуулж, хамтран ажиллаж байна.

Аймгийн удирдлага, төрийн захиргааны байгууллагуудтай байнга мэдээлэл солилцон ажиллаж, тэдний зүгээс тавьсан хууль ёсны шаардлагыг цаг тухайд нь биелүүлж ажиллаж ирсэнээр манай компанийн үйл ажиллагаанд өгөх тэдний үнэлэмж өсөж хүлээн зөвшөөрөгдсөн.

Компанийн хэмжээнд хэрэглэгчид рүү харсан тэдэнд итгэлтэй үйл ажиллагаа явуулж чанарыг эрхэмлэн ажилласнаар тэдний итгэл хүндэтгэлийг хүлээж найрсаг харьцаа бий болсон нь үйл ажиллагаа, нүүрс борлуулалтнаас харагдаж байна гэж үзэж байна.

Тухайлбал худалдан авагчидад борлуулалтын байр нь дээр пост машин байрлуулан НӨАТ-ын падааныг ямар нэг чирэгдэлгүй олгодог болсон нь хэрэглэгчдийн талархалыг хүлээсэн ажил болж чадсан байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд Аймгийн нэгдсэн эмнэлэг, Сагсан бөмбөгийн холбоо, Сүхбаатар сумын ЗДТГ, Ахмадын холбоо, хээрийн түймэрт өртсөн иргэд, амьдралын түвшин доогуур зорилтот бүлгийн иргэдэд хандив тусламж өгч ажиллаа.

4. Уулын ажлын чиглэлээр

Тайлант 2017 оны хөрс хуулалтын ажлын онцлог гэвэл уурхайн 42 жилийн түүхэнд хуулж байгаагүй их хэмжээний хөрсийг хуулж, мөн тодорхой нөхцөл

[Type text]

байдлуудад цаг алдахгүй инженерийн шийдлүүд гарган ажилласнаар өвлийн улиралд хэрэглэгчдийн хэрэгцээт нүүрсийг нийлүүлэх компани цаашид уулын ашиглалтын нөхцөлийн хувьд жигд найдвартай ажиллах эхлэл тавигдсан гэж үзэж байна

Нөхөд өө!

Компанийн санхүү, эдийн засгийн өнөөгийн хүрсэн түвшин, ирээдүйн хандлагыг тодорхойлох, санхүүгийн бодлого, ирээдүйн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн бололцоог үнэлэн тодорхойлж, удирдлагын оновчтой шийдвэр гаргахад санхүүгийн тайлангийн шинжилгээ нь чухал ач холбогдолтой юм.

Компанийн 2017 оны санхүүгийн тайланг үндэслэн дараах санхүүгийн шинжилгээнүүдийг хийлээ.

1. Хөрөнгийн бүрэлдэхүүн, динамикийн шинжилгээ

Тайлант хугацаанд компанийн нийт хөрөнгө өмнөх оноос 21.8 хувиар өссөн эерэг үзүүлэлтэй байна. Энэ нь эргэлтийн хөрөнгө 42.5 хувиар, эргэлтийн бус хөрөнгө 9.2 хувиар тус тус өссөнтэй холбоотой байна. Эргэлтийн хөрөнгө 42.5 хувиар өссөн нь дансны авлага 13.0 хувиар өссөн буюу зээлээрх борлуулалт нэмэгдсэн, бараа материал 377.6 хувиар өссөн буюу түүхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, хангамжийн материалын нөөц тус тус нэмэгдсэнийг харуулж байна. Эргэлтийн бус хөрөнгө 9.2 хувиар өссөн нь компани бүтээн байгуулалт хийж барилга байгууламж нэмэгдсэн, тоног төхөөрөмж шинээр худалдаж авсантай холбоотой.

Компанийн нийт хөрөнгийн 44.4 хувийг эргэлтийн хөрөнгө, 55.7 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна. Хөрөнгийн эх үүсвэрийн 51.3 хувийг өөрийн эх үүсвэр, 48.7 хувийг гадны эх үүсвэр буюу богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Нийт өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 30.7 хувиар өссөн нь богино хугацаат өр төлбөр нэмэгдсэнтэй холбоотой. Богино хугацаат өр төлбөрийн ихэнх буюу 72.4 хувийг дансны өглөг, 24.8 хувийг татварын өр эзэлж байна. Богино хугацаат өр төлбөр нэмэгдэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь компанийн авлага цуглахгүй байгаатай холбоотой.

Дансны өглөгийг авч үзэхэд бэлтгэн нийлүүлэгчид өгөх-392.6 сая, худалдан авагчдад өгөх-7.4 сая, хувь хүмүүст өгөх-300.3 сая, ажилчдад өгөх-22.9 сая төгрөг буюу нийт 723.2 сая төгрөг байна.

[Type text]

Татварын өглөгийг авч үзэхэд ААНОАТ-52.9 сая, ХХОАТ-29.6 сая, НӨАТ-112.9 сая, АМНАТ-43.4 сая, бусад татварын өр 9.3 сая төгрөг буюу нийт 248.1 сая төгрөг байна.

Эзэмшигчийн өмч өмнөх оноос 13.4 хувиар өссөн эерэг үзүүлэлтэй байна. Энэ нь тайлант хугацаанд ашигтай ажиллаж улмаар хуримтлагдсан ашиг 108.5 сая төгрөгөөр буюу 35.5 хувиар өссөнтэй холбоотой.

Цэвэр эргэлтийн хөрөнгө (*Цэвэр эргэлтийн хөрөнгө = Эргэлтийн хөрөнгө - Богино хугацаат өр төлбөр*) нь өөрийн хөрөнгөөр санхүүжигдсэн эргэлтийн хөрөнгийн хэмжээг илэрхийлнэ. Компанийн хувьд цэвэр эргэлтийн хөрөнгө нь - 150.0 сая төгрөг байгаа нь эргэлтийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж чадаагүйг харуулж байна.

2. Төлбөрийн чадварын шинжилгээ

Төлбөрийн чадвар гэдэг нь бусдын өмнө хүлээсэн санхүүгийн хариуцлага юм. Компанийн төлбөрийн чадварыг төлбөрийн хэрэгсэл болон өр төлбөрийн харьцаагаар тодорхойлж үзэхэд компанийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болон авлага 603.8 сая төгрөг, богино хугацаат өр төлбөр 999.5 сая төгрөг буюу өр төлбөрийн дүн нь 395.7 сая төгрөг байгаа нь төлбөрийн чадвар хангалтгүй байна.

Мөн түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа 0.6, эргэлтийн харьцаа 0.8, төлөгдөх хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин 0.6 гэсэн үзүүлэлтүүдтэй байгаа нь төлбөрийн чадвар хангалтгүй байгааг харуулж байна.

Төлбөрийн чадварыг сайжруулахын тулд богино хугацаат өр төлбөрийн бууруулах шаардлагатай байна. Үүнд:

- Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах
- Борлуулалтын авлагын цуглуулалтыг эрчимжүүлэх
- Гэрээнд заасан алдангийг тооцож, харилцагч байгууллагуудаас нэхэмжлэх
- Харилцагч байгууллагуудаас авлага барагдуулах, хуваарь гаргуулах
- Дансын өглөгт бүртгэгдсэн хувь хүмүүст өгөх 300.3 сая төгрөгийн өглөгийг урт хугацаат өр төлбөрт шилжүүлэх талаар гэрээ, хэлцэл хийх

3. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

Компанийн хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ, бүтэц бүрэлдэхүүн, түүний өөрчлөлт зэрэг нь санхүүгийн тогтвортой байдлыг харуулах үндсэн үзүүлэлт болдог.

[Type text]

Тайлант онд компанийн бие даах чадварын коэффициент 0.5, өр төлбөрийн хувийн жин 0.5 байгаа нь гадны эх үүсвэрээс хараат буюу өөрийн санхүүжилтээр бие дааж үйл ажиллагаа явуулах чадвар 50.0 хувьтай буюу нийт хөрөнгийн 50.0 хувийг гадны хөрөнгөөр санхүүжүүлж байгааг харуулж байна. Иймд компанийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлт дундаж түвшинд байна.

4. Хөрөнгийн ашиглалтын шинжилгээ

Эргэц нь эргэлтийн хөрөнгийн нэг хэлбэрээс нөгөөд шилжих хөдөлгөөнийг илэрхийлдэг. Эргэц түргэсэхийн хэрээ үйлдвэрлэлийн үр ашиг нэмэгддэг. Манай компанийн авлагын эргэц 2016 онд 150 өдөр байсан бол 2017 онд 200 өдөр болж 50 өдрөөр удааширсан байна. Өөрөөр хэлбэл авлага төлөгдөх хугацаа удаан байна. Мөн эргэлтийн хөрөнгийн эргэц 2016 онд 171 өдөр байсан бол 2017 онд 276 өдөр болж 105 өдрөөр удааширсан байна. Иймд авлагыг цуглуулах талаар анхаарах зайлшгүй шаардлагатай байна.

5. Орлого үр дүнгийн шинжилгээ

Компанийн борлуулалтын орлого өмнөх оноос 14.8 хувиар буурсан үзүүлэлтэй байгаа нь манай томоохон харилцагч болох Дөрвөлж ОӨҮГ-ын тээвэр саатсантай холбоотой бөгөөд, 2018 онд төлөвлөсөн борлуулалтыг нөхөн бололцоо бүрдсэн. Нөгөөтэйгүүр компани тайлант оны борлуулалтыг буруу бүртгэсэнтэй холбоотой байна.

Цаашид компанийн үйлдвэрлэл болон борлуулалтын төлөвлөгөөг санхүүгийн тайлагналтай уялдуулах зайлшгүй шаардлагатай байна.

Харин борлуулсан бүтээгдэхүүний өртөгийн орлогод эзлэх хувь өмнөх онтой харьцуулахад 3.8 хувиар буурсан эерэг үзүүлэлтэй байна.

Тайлант хугацаанд борлуулалт маркетингийн зардалд 15.3 сая төгрөг зарцуулсан нь өмнө жилд удирдлагын зардалд оруулж тооцдог байсан борлуулалтын ажилтантай холбоотой зардлуудыг ангилсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд ерөнхий ба удирдлагын зардал 43.4 хувиар, санхүүгийн зардал 130.0 хувиар, бусад зардал 26.3 хувиар тус тус өссөн үзүүлэлтэй байна. Ерөнхий ба удирдлагын зардал өссөн шалтгаан нь цалингийн зардал, мэргэжлийн үйлчилгээний төлбөр, түрээсийн зардал нэмэгдсэнтэй, санхүүгийн зардал өссөн нь хувь хүнээс авсан зээл нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Орлого буурсан, үйл ажиллагааны зардлууд өссөнтэй холбоотойгоор татварын өмнөх ашиг 45.2 хувиар буурсан байна.